

<p align="center"><i>“Шарын гол” ХК-ийн ТУЗ-ийн хурлын 2016 оны дугаар сарын ___ –ны өдрийн ___ тоот тогтоолоор батлав</i></p>	<p align="center"><i>Approved by the resolution no... datedof 2016 at Board of Directors Meeting of “SharynGol”JSC</i></p>
<p align="center">“ШАРЫН ГОЛ” ХК-ИЙН МЭДЭЭЛЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ</p>	<p align="center">“SHARYN GOL” JSC’S PUBLIC DISCLOSURE INFORMATION REGULATION</p>
<p align="center">Нэг. Нийтлэг үндэслэл</p>	<p>One. General Provision</p>
<p>1.1 Энэхүү журмын зорилго нь: Санхүүгийн зохицуулах хорооноос /цаашид “хороо” гэх/ баталсан “Компанийн засаглалын кодекс” болон “Үнэт цаас гаргагчийн мэдээллийн ил тод байдлын журам”-д нийцүүлэн компани өөрийн үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг хөрөнгө оруулагчид хувьцаа эзэмшигчдэд шаардлагатай мэдээллийг хүргэх, мэдээллийн ил тод байдлыг хангах, үйл ажиллагааг зохицуулахад оршино.</p> <p>1.2 Компани нь компанийн тухай хууль, үнэт цаасны зах зээлийн тухай хууль, үнэт цаас гаргагчийн мэдээллийн ил тод байдлын журамд заасан холбогдох мэдээллийг нийтэд мэдээлэх үүрэг хүлээнэ.</p> <p>1.3 Компанийн аливаа мэдээллийг монгол хэлээр өөрийн болон хөрөнгийн биржийн цахим хуудас болон хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд хүргэнэ.</p>	<p>1.1 The objective of the regulation is: To regulate the activity to disclose the information concerning the company’s own activity to the shareholders and the public by adjusting to the “Governance Codex of Joint Stock Company” and “Security issuer’s regulation on publically providing information” approved by the Financial Regulatory Committee(hereinafter “Committee”) and the Company Law and regulation.</p> <p>1.2 Company is responsible for providing information followed by Company Law, Securities Market law, and Security issuer’s regulation on providing information to public.</p> <p>1.3 Public disclosure information must provide through Mongolian Stock Exchange web page, company’s web page and other sources in Mongolian.</p>
<p align="center">Хоёр. Хугацаат тайланг нийтэд мэдээлэх</p>	<p align="center">Two. Informing report to public</p>
<p>2.1 Хугацаат тайлан нь хагас жилийн, жилийн үйл ажиллагаа гэсэн 2 хэлбэртэй байна.</p> <p>2.2 Хагас жилийн үйл ажиллагааны тайланг 8 сарын 01-ний өдрийн, жилийн үйл ажиллагааны тайланг дараа жилийн 01-ний өдрийн дотор тус тус нийтэд мэдээлнэ.</p> <p>2.3 Жилийн үйл ажиллагааны тайлан нь доорхи мэдээллийг агуулна.</p>	<p>2.1 Reports are two type, annual and half year operation report.</p> <p>2.2 Half-year operation report will become public before August 1st, and annual operation report will become public before January first of following year.</p> <p>2.3 Annual operation report will cover following information:</p>

<p>2.3.1 Компанийн үйлдвэрлэлийн үйл ажиллагаа буюу бизнесийн үйл ажиллагааны мэдээлэл:</p> <p>2.3.1.1 Компанийн үйл ажиллагааны (бизнес) төлөвлөгөө, түүний хэрэгжилтийн талаарх мэдээлэл</p> <p>2.3.1.2 Компанийн бараа, бүтээгдэхүүн, үйлчилгээний зах зээлд гарсан томоохон өөрчлөлт, үүнтэй холбогдон үүсч болох эрсдэлийн тухай мэдээлэл</p> <p>2.3.1.3 Тайлант хугацаанд компанийн үйл ажиллагаанд гарсан томоохон үйл явдлын талаарх мэдээлэл</p> <p>2.3.2 Компанийн удирдлагын талаарх мэдээлэл:</p> <p>2.3.2.1 Компанийн удирдлагын бүтэц, бүрэлдэхүүнд орсон өөрчлөлт.</p> <p>2.3.2.2 Компанийн ТУЗ, гүйцэтгэх удирдлага болон бусад эрх бүхий албан тушаалтны талаарх мэдээлэл.</p> <p>2.3.2.3 Компанийн ТУЗ болон, ТУЗ-ийн дэргэдэх хороодын үйл ажиллагааны тайлан.</p> <p>2.3.2.4 ТУЗ, гүйцэтгэх удирдлага бусад эрх бүхий албан тушаалтны цалин урамшууллын хэмжээ, тэдгээрийн эзэмшиж буй хувьцааны талаарх мэдээлэл.</p> <p>2.3.3 Санхүүгийн байдлын талаарх мэдээлэл:</p> <p>2.3.3.1 Компанийн хагас жилийн санхүүгийн тайлан, түүнд хийсэн дүн шинжилгээ.</p> <p>2.3.3.2 Аудитын байгууллагаар баталгаажуулсан тухайн жилийн санхүүгийн тайлан, аудиторын дүгнэлт, тодруулга.</p> <p>2.3.3.3 Компанийн тухай хуульд заасан их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй</p>	<p>2.3.1 Information on Company’s production and business operation.</p> <p>2.3.1.1 Information on company operation. Business plan and performance of the plan.</p> <p>2.3.1.2 Information on the company’s products, goods, big change in the market of service, and risk that may arise from it.</p> <p>2.3.1.3 Information on massive changes happened in the operation during annual report year.</p> <p>2.3.2 Information on executive body of company:</p> <p>2.3.2.1 Changes in the management structure and executive bodies of the company.</p> <p>2.3.2.1 Information on members of Board of Directors and other managements who has role in the decision-making.</p> <p>2.3.2.1 Operation report of Board of Directors and committees of Board of Directors.</p> <p>2.3.2.1 Salary earning and shareholding information of the governing person of executive member’s and members of the Board of Director.</p> <p>2.3.3 Information on financial position:</p> <p>2.3.3.1 Company’s half-year financial report and analysis on report.</p> <p>2.3.3.2 Approved annual audited financials reports and its analysis and clarification from auditor.</p> <p>2.3.3.3 Information on massive bargain and activities involving conflict of interest followed by company’s law.</p>
---	---

<p>хэлцлийн талаарх мэдээлэл.</p> <p>2.3.3.4 Тухайн жилд авсан зээл, зээлийн эргэн төлөлтийн талаарх мэдээлэл.</p> <p>2.3.4 Хувьцаа эзэмшигчдийн талаарх мэдээлэл:</p> <p>2.3.4.1 Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурал, түүний шийдвэрийн мэдээлэл.</p> <p>2.3.4.2 Компанийн эрх бүхий албан тушаалтан болон нөлөө бүхий хувьцаа эзэмшигчдийн өөрчлөлт.</p> <p>2.3.4.3 Компанийн дүрэмд орсон өөрчлөлтийн тухай мэдээлэл.</p> <p>2.3.5 Компанийн ногдол ашгийн талаарх мэдээлэл:</p> <p>2.3.5.1 Компанийн ногдол ашгийн талаарх бодлого.</p> <p>2.3.5.2 Компанийн тухайн жилийн ашгаас хуваарилсан ногдол ашгийн хэмжээ түүнийг тараах хэлбэр, хугацаа болон ногдол ашиг хуваарилаагүй бол түүний шалтгааны талаарх мэдээлэл.</p>	<p>2.3.3.4 Information on processed loan amount and its payment schedule of the annual year.</p> <p>2.3.4 Information on Shareholders:</p> <p>2.3.4.1 Information on shareholders meeting and meeting decisions.</p> <p>2.3.4.2 Information on changes made in the measure shareholder and executive person of the company.</p> <p>2.3.4.3 Information on changes in the charter of the company.</p> <p>2.3.5 Company's dividend information:</p> <p>2.3.5.1 Company's policy on dividend.</p> <p>2.3.5.2 Information on dividend's amount, dividing, time and explanation if not distributing dividend.</p>
<p>Гурав. Тухай бүр нийтэд мэдээлэх мэдээлэл</p> <p>3.1 Компанийн ТУЗ болон гүйцэтгэх удирдлага нь хувьцаа эзэмшигчид, хөрөнгө оруулагчдад компанийн үйлдвэрлэлийн үйл ажиллагаа болон санхүүгийн байдал, эдийн засгийн үзүүлэлт, удирдлага зохион байгуулалтын бүтэцтэй холбоотой мэдээллийг тухай бүр нийтэд мэдээлнэ.</p> <p>3.2 Тухай бүр нийтэд хүргэх мэдээлэл нь дараах мэдээлэл байна.</p> <p>3.2.1 Санхүүгийн мэдээлэл:</p> <p>3.2.1.1 Компанийн хөрөнгө, үйл ажиллагаанд чухал нөлөө үзүүлэх гэрээ хэлцэл байгуулах.</p> <p>3.2.1.2 Компани, хөндлөнгийн аудиторын байгууллагатай байгуулсан гэрээ, түүний өөрчлөлтийн талаарх мэдээлэл.</p>	<p>Three. Information distributing in every occasion.</p> <p>3.1 Board of Director and governing person will distribute operation report, economics, financial report, and management structure information's to shareholders in every occasion.</p> <p>3.2 Distributing disclosure information in every occasion will be as follows:</p> <p>3.2.1 Information on financials:</p> <p>3.2.1.1 When dealing of bargain could affect company's assets and operation.</p> <p>3.2.1.2 A contract made with or changed the company's auditor</p> <p>3.2.1.3 Information on conflict of interest</p>

<p>3.2.1.3 Сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцлийн талаарх мэдээлэл.</p> <p>3.2.1.4 Үл хөдлөх хөрөнгийн 10 ба түүнээс дээш хувьтай тэнцэх хөрөнгийг худалдах, барьцаалах, бусдад шилжүүлэх, битүүмжлэх, тусгаарлах.</p> <p>3.2.1.5 Төлбөрийн чадваргүй болох.</p> <p>3.2.1.6 Компанийн өрийн хувьцаагаар солих.</p> <p>3.2.2 Санхүүгийн бус мэдээлэл:</p> <p>3.2.2.1 Компанийн үйл ажиллагааны чиглэл өөрчлөгдсөн, үйл ажиллагаа нь түр болон бүрэн зогссон.</p> <p>3.2.2.2 Компани үйл ажиллагаандаа шинэ техник, технологи нэвтрүүлэх, шинэ бүтээгдэхүүн зах зээлд танилцуулах.</p> <p>3.2.2.3 Шинэ бүтээгдэхүүнд зориулан тусгай зөвшөөрөл, патент авч, үйл ажиллагаа явуулах эрх, барааны тэмдэг эзэмших болон цуцлах.</p> <p>3.2.2.4 Компанийн оноосон нэр, хаяг өөрчлөгдсөн.</p> <p>3.2.2.5 Салбар төлөөлөгчийн газар байгуулах, татан буулгах.</p> <p>3.2.2.6 Бусад компанийн хувьцааны хяналтын багц болон түүнээс дээш хувийг худалдах, худалдан авах.</p> <p>3.2.2.7 Компанийн нэгдэх, нийлэх, хуваах тусгаарлах зэргээр өөрчлөн батлуулах, өөрчлөх шийдвэр.</p> <p>3.2.2.8 Хувьцааны опцион болон хувьцаа эзэмшигч, компанийн хувьцааг эхний ээлжинд худалдан авах эрх бүхий нэмэлт хувьцаа гаргах.</p> <p>3.2.2.9 Компанийн хувьцааг хуваах, нэгтгэх шийдвэр.</p> <p>3.2.2.10 Компанийг татан буулгах шийдвэр.</p>	<p>transaction happened.</p> <p>3.2.1.4 Any activity that contains more than 10 percent of the company's asset has been sold, deposited, transferred to others, discarded and sealed.</p> <p>3.2.1.5 When became bankruptcy</p> <p>3.2.1.6 Replacing company with debt shares</p> <p>3.2.2 Non financial information:</p> <p>3.2.2.1. When changes made in operation or when operation completely shut down.</p> <p>3.2.2.2 When company introducing new tech, technology in operation and new product into market.</p> <p>3.2.2.3 Receiving new operation license and patent for new product or canceling product code on operation license.</p> <p>3.2.2.4 Changes in the company's address and name.</p> <p>3.2.2.5 Representative office and branch opening or closing</p> <p>3.2.2.6 Made a purchase or sell of other companies shares and controlling shares.</p> <p>3.2.2.7 Decision made on combination or separation of company.</p> <p>3.2.2.8 Stock option or shareholders when purchasing company's shares or issuing additional shares.</p> <p>3.2.2.9 Separating or purchasing the securities of company.</p> <p>3.2.2.10 Decision on shutting down the company.</p>
--	--

<p>3.2.3 Удирдлагын талаарх мэдээлэл:</p> <p>3.2.3.1 Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах шийдвэр, хурлын зар, хурлаас гарах шийдвэрийн төсөл, бусад материал.</p> <p>3.2.3.2 Компанийн ТУЗ-өөс гаргасан хувьцаанд нөлөөлөх аливаа шийдвэр.</p> <p>3.2.3.3 Компанийн нөлөө бүхий хувьцаа эзэмшигч болон тэдгээрийн бусад компанид эзэмшиж буй хувьцаанд гарсан өөрчлөлт.</p> <p>3.2.3.4 ТУЗ-ийн бүрэлдэхүүний өөрчлөлт.</p> <p>3.2.3.5 Нийт хувьцааны хяналтын багц эзэмшигчид болон эрх бүхий албан тушаалтнуудын гэмт хэрэг үйлдсэн нь шүүхээр тогтоодсон.</p> <p>Дөрөв. Нийтэд мэдээлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх</p> <p>4.1 Энэ журмын 2.3, 3.2-т заасан мэдээллийг өөрийн болон МХБ-ийн цахим хуудсанд байршуулах үүргийг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга гүйцэтгэх бөгөөд мэдээллийн үнэн зөвийг компани хариуцана.</p> <p>4.2 Компанийн ТУЗ, гүйцэтгэх удирдлага нь мэдээллийг нээлттэй болгох үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомж болон энэхүү журмын хугацаанд мэдээлж байгаа эсэхэд хяналт тавина.</p> <p>Тав. Мэдээллийг нийтэд хүргэхэд тавигдах хязгаарлалт</p> <p>5.1 Компанийн дотоод мэдээлэл эзэмшигч нь уг мэдээллийг энэ журмын дагуу мэдээлэхээс өмнө уг мэдээллийг санамсаргүй болон санаатайгаар мэдээлэх, дамжуулах, бусдад олж авах нөхцөлийг бүрдүүлэхийг хориглоно.</p> <p>5.2 Компани нь төөрөгдүүлсэн хуурамч, бүрэн бус мэдээллийг нийтэд мэдээлэхийг хориглоно.</p> <p>5.3 ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь олгогдсон эрхийг компанийн ТУЗ-ийн зөвшөөрөлгүйгээр ашиглахыг хориглоно.</p>	<p>3.2.3 Information on executive body of company.</p> <p>3.2.3.1 Decision of calling shareholders meeting, shareholders meeting decision, resolution draft and other materials.</p> <p>3.2.3.2 When Board of Directors decision has affected company shares.</p> <p>3.2.3.3 When company's top shareholders and their other shares in other company has been changed.</p> <p>3.2.3.4 When members of the Board of directors has changed.</p> <p>3.2.3.5 When Court has approved the top shareholders or executive body has been committed to any crime activity.</p> <p>Four. Implementing the process of making information become public.</p> <p>4.1 The article 2.3 and 3.2 of the regulation states public disclosure can become public through Mongolian stock exchange web page or company's web page or other sources; therefore company is responsible on information's accuracy.</p> <p>4.2 Company's Board of Director's are responsible for double checking information timing and following rules of any regulations.</p> <p>Five. Limit for information becoming public</p> <p>5.1 Inside information holder prohibited to give out information accidently or purposely to outsider before making information public.</p> <p>5.2 The company is prohibited to give out wrong information.</p> <p>5.3 Board secretary is prohibited to over use his position without Board of directors approval.</p>
---	--

Зургаа. Хариуцлага	Six. Responsibility
<p>6.1 Энэхүү журмыг зөрчсөн хариуцлагатанд холбогдох хууль тогтоомж, компанийн дотоод журманд заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.</p> <p>6.2 Аливаа мэдээллийн үнэн зөвийг уг мэдээг боловсруулсан болон хянасан албан тушаалтан хариуцна.</p> <p>6.3 Энэхүү журмыг зөрчсөнөөс холбогдон үүсэх хохирлыг хариуцлага ногдуулсан эсэхээс үл хамааран буруутай этгээд нөхөн төлж барагдуулна.</p>	<p>6.1 A person who breaks this regulation shall take responsibility in accordance with associated laws and the company's internal regulation.</p> <p>6.2 An official who develops and checks the information shall take responsibility of truth and correction of any information.</p> <p>6.3 Any loss caused due to breaking this regulation shall be covered by a guilty person not depending on the responsibility</p>